



Yale University

**Certificate Course in  
Healthcare Management**



**Paul Taheri**

**Йэлийн Анагаах Ухааны  
Сургуулийн Гүйцэтгэх Захирал,  
Эмнэлгийн Удирдлага хөтөлбөрийн  
дэд эрхлэгч асан**

## **Эрүүл Мэндийн Салбарын Удирдлага Цахим Сургалтад Тавтай морил!**

Юуны түрүүнд, Монгол улсад эрүүл мэндийн салбарыг түүчээлэгч салбарын лидерүүд,, улсын болон хувийн эмнэлгийн гүйцэтгэх удирдлагууд та бүхэнд халуунаар мэндчилье.

АНУ-ын шилдэг 10 сургуулийн 4 дүгээрт, дэлхийд чансаагаараа 10 дугаарт эрэмбэлэгддэг, 300 жилийн түүхтэй манай Йел Их Сургуулийн, Анагаахын Сургуулийн хамгийн өндөр үнэлгээтэй хөтөлбөрүүдийг тэргүүлдэг “Эрүүл Мэндийн Салбарын Удирдлага” цахим сургалтыг Өв Орчин Үеийн Боловсролын Хүрээлэн ТББ болон Улаанбаатар Хотын Глория эмнэлэгтэй хамтран бид анх удаа Монгол Улсад зохион байгуулах болсныг баяртайгаар дуулгая.

Та бүхний мэдэж байгаачлан эрүүл мэндийн удирдлага гэдэг комплекс ухагдахуун бөгөөд гүйцэтгэх удирдлага, менежерүүдээс удирдан, зохион байгуулах нарийн ур ухаан, чадвар шаарддаг. Тиймээс, үр дүнтэй удирдлагын зарчмуудыг хэрэгжүүлснээр салбарынхаа ирээдүйн хөгжилд үнэтэй хувь нэмрээ оруулахад тань манай хөтөлбөр таны ур чадварыг хурцалж, мэдлэгийг тэлнэ гэдэгт итгэлтэй байна.

Монгол улсад зохион байгуулагдах “Эрүүл Мэндийн Салбарын Удирдлага” хөтөлбөрийн анхны суралцагчид болохоор шийдсэн та бүхнийг дахин халуунаар угтан авахын зэрэгцээ, бизнестээ шууд хэрэгжүүлж болох үр дүнтэй санаанууд, менементийн шинэ ойлголт, мэдлэгээр цэнэгдсэн гайхалтай 8 долоо хоногийг танд амлаж байна.

Хүндэтгэсэн,

Паул Тахери





## Хөтөлбөрийн тухай

Эмчилгээний үр дүн эмчийн чадвараас хамаардаг бол эрүүл мэндийн байгууллагыг үр ашигтай зохион байгуулах нь удирдагчийн санхүү, менежментийн талаарх мэдлэг, тэдгээрийг хэрэгжүүлэх ур чадвараас шалтгаалдаг.

Удирдах албан тушаалтнуудад зориулсан Йел Их Сургуулийн “Эрүүл Мэндийн Салбарын Удирдлага” цахим хөтөлбөр танд эмнэлгийн байгууллагыг үр ашигтай зохион байгуулах менежментийн суурь зарчмууд болон эмнэлгийн байгууллагын бүтэц, захиргааны талаарх үнэ цэнтэй ойлголтыг өгөх болно.

Тус хөтөлбөрт хамрагдсанаар та эмнэлгийн байгууллагыг үр дүнтэй зохион байгуулах, бизнесийн ашиг орлогоо нэмэгдүүлэхийн зэрэгцээ үйлчилгээний чанарыг сайжруулах менежментийн ухаан, ур чадварт суралцах юм.

**Эрүүл мэндийн удирдлагад бизнесийн суурь зарчмуудыг ашиглах, менежмент, санхүүгийн арга ухаанд суралцъя!**



## Хөтөлбөрийн агуулга

### Модуль 1.

#### Эрүүл мэндийн салбарын эдийн засаг

##### Удиртгал хичээл

Салбарын эдийн засгийн тогтолцоог тодорхойлогч хүчин зүйлсийг ойлгон, эмнэлгийн байгууллагын зардал, маржиныг тооцоолох. Үүнд:

- Эмнэлгийн зардлыг тодорхойлдог эдийн засгийн хэмжигдэхүүнүүдийг судлах
- Эрүүл мэндийн салбарын маржиныг хэрхэн тооцож, тайлагнах вэ?
- Зардал, маржины шинжилгээнд суурилан оновчтой шийдвэр гаргах нь
- Эмнэлгийн байгууллагын үр ашгийг нэмэгдүүлэхийн ач холбогдол
- Эрүүл мэндийн салбарын эдийн засгийг тодорхойлогч макро, микро хүчин зүйлсийг судална.

### Модуль 2.

#### Эрүүл мэндийн салбарын санхүүгийн эх үүсвэр

Эрүүл мэндийн салбарын гол санхүүжүүлэгчдийг тодорхойлж, эмнэлгийн зардал болон эмч нарын цалинг тогтоодог механизмыг ойлгох. Үүнд:

- Эрүүл мэндийн үйлчилгээг санхүүжүүлэх төлөвлөгөөт төлбөрийн хэлбэрүүдийг ойлгох
- Эрүүл мэндийн үйлчилгээний зардлыг эмнэлгүүдэд нөхөн олгох механизм
- Үйлчилгээ үзүүлсэн эмчийн төлбөрийг хэрхэн тогтоох вэ?
- Эмчилгээний зардал, улсаас даатгалаар олгож буй нөхөн төлбөр болон эмчийн үзлэгийн зардал зэргийн төлбөрийн бүтэцийг авч үзнэ.

### Модуль 3.

#### Үйл ажиллагааны удирдлага ба эрүүл мэндийн үйлчилгээ

Энэ сэдвийн хүрээнд эмнэлгийн үйлчилгээний үр дүнг сайжруулах боломжуудыг судлах юм. Үүнд:

- Эмнэлгийн үйл ажиллагаанд “жижииглэх хуулийн” онолыг ашиглах нь
- Эмнэлгийн хүчин чадлыг хязгаарлаж буй бүтцийн цоорхой, үйл ажиллагааны алдаа эндэгдлийг тодорхойлох
- Үйл ажиллагааны доголдлыг арилгаж,, эмчилгээний үр дүн болон үйлчилгээний чанарыг сайжруулахын үр ашиг
- Үйл ажиллагааны алдаа, доголдлыг бууруулах арга, хэрэгслүүд

### Модуль 4.

#### Өвчтөний эрх болон эмчийн ашиг сонирхлыг тэнцвэртэй хангах нь

Ашиг сонирхлын зөрчил үүсэхэд өвчтөний болоод эмчлэгчийн эрх ашгийг тэнцвэртэй хангахын тулд эрүүл мэндийн тухай хуулийг ойлгож, нийцүүлэх. Үүнд:

- Эрүүл мэндийн тухай хуулийн үндсэн элемент
- Эмч, эмнэлгийн ажилтнуудыг эрүүл мэндийн хуульд нийцүүлэн ажиллахад чиглүүлсэн хөтөлбөртэй байхын давуу тал
- Өвчтөнтэй үүссэн зөрчил, маргааныг тодорхойлж, шийдвэрлэх
- Эмч, өвчтөний хооронд үүссэн маргаан, зөрчлийг үр дүнтэй удирдаж, шийдвэрлэх аргачлалуудтай танилцана.

## **Модуль 5.**

### **Эрүүл мэндийн системийн санхүүгийн тулгуур зарчмууд**

Энэ сэдвийн хүрээнд эмнэлгийн үйлчилгээний үр дүнг сайжруулах боломжуудыг судлах юм. Үүнд:

- Олон улсын эрүүл мэндийн тогтолцоонд тулгарч буй санхүүгийн тулгамдсан нөхцөл байдлууд
- Санхүүгээ үр дүнтэй удирдахад нөлөөлөгч чухал хүчин зүйлс
- Эрүүл мэндийн үйлчилгээнд санхүүгийн анхан шатны дүн шинжилгээ хийх

## **Модуль 6.**

### **Капиталын хөрөнгө оруулалтыг төсөвлөхөд эмчийн үүрэг, оролцоо**

Капиталын хөрөнгө оруулалтын төсөв боловсруулах модел болон уг үйл явцыг амжилттай удирдсанаар эрүүл мэндийн тогтолцоонд урт хугацаандаа бий болох өгөөжийг ойлгох нь. Үүнд:

- Ашгийн болон ашгийн бус эрүүл мэндийн тогтолцооны ялгаа
- Эрүүл мэндийн салбарт капиталын хөрөнгө оруулалт хийх хэрэгцээ, шаардлага
- Эрүүл мэндийн системд төсөв боловсруулах стратегийг хэрэгжүүлэх нь
- Капиталын хөрөнгө оруулалтыг төсөвлөхтэй холбоотой эрсдэлийн таамаглах
- Капиталын хөрөнгө оруулалтыг төсөвлөхөд эмчийн гүйцэтгэх үүрэг, оролцоог тайлбарлана.

## **Модуль 7.**

### **Эмч нараа зохион байгуулах**

Эмч нар болон эмнэлгийн ажилтнуудын дагаж мөрдөх дотоод журам, бизнесийн бүтцүүдтэй танилцан,, байгууллагын стратегийг чиглүүлэх зарчмуудыг судална. Үүнд:

- Эрүүл мэндийн салбарт эмч нар болон эрүүл мэндийн ажилтнуудыг хэрхэн зохион байгуулах вэ?
- Эмчилгээний чанартай холбоотой эмчийн хариуцлагыг тодорхойлох
- Эмч нараа зохион байгуулах, санхүүжүүлэх, урамшуулах
- Эмнэлэг байгуулах зорилгоор зах зээлийн дүн шинжилгээ хийх

## **Модуль 8.**

### **Эмчийн манлайлал**

Зохион байгуулах ур чадварыг хөгжүүлэн, эрүүл мэндийн салбарт эмч нарын манлайллыг нэмэгдүүлэх. Үүнд:

- Манлайлагч эмчийн эзэмшвэл зохих менежментийн ур чадварууд
- Эрүүл мэндийн системд тулгамдаж буй хүндрэл, бэрхшээлийг эмчийн шийдвэрлэхэд манлайлал чухал үүрэг гүйцэтгэнэ
- Манлайлагчийн чухал шинж чанарууд
- Эмчийн удирдан, зохион байгуулах авьяас чадварт тулгуурлан, эрүүл мэндийн салбарт эмч нарын манлайлал, нөлөөллийг нэмэгдүүлэх



## Сургалтыг зохион байгуулах хэлбэр

Эрүүл Мэндийн Салбарын Удирдлага хөтөлбөр нь видео хичээлүүд, гарын авлага зэрэг уншиж судлах материалуудаас бүрдсэн 100 хувь цахим сургалт билээ.

Гэвч, хөтөлбөрийн агуулгыг бүрэн, зөв ойлгож, улмаар ажлын талбартаа итгэл дүүрэн хэрэгжүүлэн, зорьсон үр дүндээ хүрэхэд тань туслахын тулд бид энэхүү 100% цахим сургалтыг тахимын сургалттай хослуулах зохион байгуулах юм.

Та 8 долоо хоногийн хугацаанд өөрийн боломжит цагаар (7 хоногт 1 модуль заавал үзнэ) хичээлээ цахимаар үзэж, судлах бөгөөд долоо хоногийн нэг өдөр танхимараар цуглан, мэргэжил нэгт бусад орлоцогч нартай шинэ мэдлэг, ойлголтоо хуваалцахын зэрэгцээ ментор багшийн тайлбартайгаар, Монгол хэл дээр сэдэв нэг бүрийн давтан судална.


Түүнчлэн хөтөлбөрийн бие даалтууд болон үзэж, судалсан сэдвүүдээ бататгах зорилготой тестүүдийг ажиллахад хэлний бэрхшээл тулгарах зэрэгт зохион байгуулагчийн зүгээс бид танд шаардлагатай техник тусламжуудыг үзүүлэх болно.

Сургалтын  
хугацаа 8 долоо  
хоног

Англи- Монгол  
хэл дээр  
суралцана

Цахим-танхим  
хосолсон

Йелийн Их  
Сургуулийн  
Сертификат



# Yale SCHOOL OF MANAGEMENT

## *Executive Education*

In recognition of the contribution and participation of

Presentation date: March 2021 - May 2021

Issue date:

A handwritten signature in black ink, reading "Kavitha Bindra", written over a horizontal blue line.

Kavitha Bindra

Assistant Dean & Executive Director

Иелгийн Их Сургуулийн  
Сертификат



# ХОЛБОО БАРИХ

## Gloria Dental Clinic

Монгол улс, Улаанбаатар хот, СБД, Нарны зам, Хүүхдийн  
паркын эсрэг талд, Тусгалт оффис, 8 давхарт

 99886360

 dr.bolormaa@gmail.com

Yale Legacy!

Institute of Modern Education

